



**ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 9/115

Эрдэнэт

Ээлжит хуралдаан зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 07 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлийн ажиллах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн Ээлжит XII хуралдааныг 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Эрдэнэт хотод зарлан хуралдуулж, дараах асуудал хэлэлцүүлэхээр тогтоосугай.

1.1. “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах” үндэсний хөдөлгөөний хүрээнд Орхон аймагт 2022-2027 онд хийгдэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай

1.2. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлах тухай

1.3. Хөтөлбөр батлах тухай

1.4. Аймгийн 2023 онд ойгоос бэлтгэх модны дээд хэмжээг батлах тухай

1.5. Аймгийн 2023 онд цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тоог тогтоох тухай

1.6. Олон нийтийн цагдаагийн тоог тогтоох тухай

1.7. Орон нутгийн өмчийн 2022 оны улсын үзлэг тооллогын дүнг батлах тухай

1.8. Аймгийн хэмжээнд 2022 онд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын төлөвлөгөөний биелэлт, 2023 онд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын төлөвлөгөө батлах тухай

1.9. Журам шинэчлэн батлах тухай

1.10. Орон тооны бус зөвлөл байгуулах тухай

1.11. Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэх тухай

1.12. Аймгийн хэмжээнд төр, сүм, хийдийн харилцааг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай

2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит XII хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3.Хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Зөвлөлийн гишүүдэд даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын  
2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн  
дугаар захирамжийн хавсралт

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ЭЭЛЖИТ XII ХУРАЛДААНЫ БЭЛТГЭЛ ХАНГАХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит XII хуралдааныг зарласан тухай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдийг мэдээллээр хангах;

XI/03-ны дотор

Ажлын алба

2."Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах" үндэсний хөдөлгөөний хүрээнд Орхон аймагт 2022-2027 онд хийгдэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай асуудлын илтгэл, танилцуулга, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын зөвлөлийн болон хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XI/03, XI/08, XI/22-ны дотор

Аймгийн Засаг дарга С.Батжаргал

3.Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлах тухай асуудлын илтгэл, танилцуулга, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын зөвлөлийн болон хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XI/03, XI/08, XI/22-ны дотор

Аймгийн ГХБХБГ-ын дарга Д.Цолмон

4.Төрийн албан хаагчийн хөгжлийн хөтөлбөр батлах тухай асуудлын илтгэл, танилцуулга, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын зөвлөлийн болон хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XI/03, XI/08, XI/22-ны дотор

Аймгийн Засаг дарга С.Батжаргал

5.Аймгийн 2023 онд ойгоос бэлтгэх модны дээд хэмжээг батлах тухай асуудлын илтгэл, танилцуулга, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын зөвлөлийн болон хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XI/03, XI/08, XI/22-ны дотор

Аймгийн БОАЖГ-ын дарга С.Жаргалсайхан

6.Аймгийн 2023 онд цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тоог тогтоох тухай асуудлын илтгэл, танилцуулга, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын зөвлөлийн болон хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XI/03, XI/08, XI/22-ны дотор

Аймгийн Засаг дарга С.Батжаргал

7.Олон нийтийн цагдаагийн тоог тогтоох тухай асуудлын илтгэл, танилцуулга, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын зөвлөлийн болон хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;



XI/03, XI/08, XI/22-ны дотор

Аймгийн Цагдаагийн газрын  
дарга С.Цэрэнсамбуу

8.Орон нутгийн өмчийн 2022 оны улсын үзлэг тооллогын дүнг батлах тухай асуудлын илтгэл, танилцуулга, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын зөвлөлийн болон хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XI/03, XI/08, XI/22-ны дотор

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын  
дарга Л.Оюунгэрэл

9.Аймгийн хэмжээнд 2022 онд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын төлөвлөгөөний биелэлт, 2023 онд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын төлөвлөгөө батлах тухай асуудлын илтгэл, танилцуулга, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын зөвлөлийн болон хурлын хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;

XI/03, XI/08, XI/22-ны дотор

Аймгийн Онцгой байдлын газрын  
дарга Г.Ганбаатар

10.Журам шинэчлэн батлах тухай асуудлын илтгэл, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын зөвлөлийн болон хурлын хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх;

XI/03, XI/08, XI/22-ны дотор

Аймгийн ИТХ-ын дарга Д.Мөнхбат

11.Орон тооны бус зөвлөл байгуулах тухай асуудлын танилцуулга, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын зөвлөлийн болон хурлын хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх;

XI/03, XI/08, XI/22-ны дотор

Аймгийн ИТХ-ын дарга Д.Мөнхбат

12.Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэх тухай асуудлын танилцуулга, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын зөвлөлийн болон хурлын хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх;

XI/03, XI/08, XI/22-ны дотор

Аймгийн Онцгой байдлын  
газрын дарга Г.Ганбаатар

13.Аймгийн хэмжээнд төр, сүм, хийдийн харилцааг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай асуудлын танилцуулга, холбогдох тооцоо судалгаа, шийдвэрийн төсөл боловсруулж Ажлын албанд ирүүлэх, Хурлын зөвлөлийн болон хурлын хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх;

XI/03, XI/08, XI/22-ны дотор

Аймгийн ИТХ-ын дарга Д.Мөнхбат

14.Хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан холбогдох хороод ажиллаж санал дүгнэлт гаргах;

XI/21-ны дотор

Холбогдох Хороод

15.Төлөөлөгчид тойрогтоо ажиллах, сонгогчидтой уулзах, хуралдаанаас гарах шийдвэрийн төсөлд тусгуулах санал асуудлыг нэгтгэж Ажлын албанд ирүүлэх;

XI/22-ны дотор

Төлөөлөгчид

16.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит XII хуралдааны бэлтгэл хангасан дүнг Хурлын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх, илтгэл илтгэгчийг батлах;

XI/08-ны дотор

Хурлын дарга Д.Мөнхбат

17.Техник зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангах;

XI/22-ны дотор

Ажлын албаны дарга Д.Эрдэнэцэцэг

**АЖЛЫН АЛБА**